

**ПАТЕНТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН
НАЙРУУЛГЫН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН
ТООЦООНЫ ТАЙЛАН**

Улаанбаатар хот

2019 он

ПАТЕНТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас боловсруулсан Патентын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл¹ /цаашид “хуулийн төсөл” гэх/ батлагдсан нөхцөлд түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал /цаашид “аргачлал” гэх/-ын дагуу тооцлоо.

Энэхүү үнэлгээний зорилго нь хуулийн төсөл батлагдсанаар иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад шинээр үүсэх зардлын ачааллыг урьдчилан тооцож, цаашид гарах зардлыг багасгах санал боловсруулахад оршино. Иймд тус тооцоог боловсруулах зорилгоор иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад хүлээлгэхээр хуулийн төсөлд тусгагдсан үүргүүдийг ангилж, шинээр нэмэгдэж буй үүргүүдийг одоогийн хууль, журмуудад тусгагдсан бөгөөд практикт гүйцэтгэж хэвшсэн үүргүүдээс ялгалаа.

Уг аргачлалын Ерөнхий зүйлийн 1.5-д заасан журмын дагуу зардлыг хуулийн этгээдийн зардал, иргэнд үүсэх зардал, төрийн байгууллагын зардал гэсэн гурван төрлөөр тооцдог боловч 1/хуулийн төсөлд иргэн, хуулийн этгээд гэдгээр ялгаж үүрэг оногдуулаагүй буюу “мэдүүлэг гаргагч”-ийн хувьд үүрэг бий болгосон, 2/оюуны өмч нь хувь хүний оюуны бүтээлч ажиллагааны дүнд үүсдэг буюу зохион бүтээгч нь хуулийн этгээд бус хувь хүн байдаг, 3/гадаад улсад үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдийн ажилтны хөлс нь тухайн улсын дундаж цалин хөлс, хуулийн этгээдийн хэмжээ, үйл ажиллагааны салбараасаа шалтгаалан хэт ялгаатай, дунджаар тооцох боломжгүй учир хуулийн этгээдэд зардал тооцохгүйгээр иргэний зардалд нийлүүлэн тооцооллоо.

Хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцоход доор дурдсан нийтлэг зарчмыг баримтлан ажилласан болно:

- Иргэн, төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг нэг бүрийг оновчтой тодорхойлох;²

¹ Патентын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл. 2018 он. <http://mojha.gov.mn/?topic=%D0%B0%D1%80%D0%B1%D0%B8%D1%82%D1%80%D1%8B%D0%BD-%D1%82%D1%83%D1%85%D0%B0%D0%B9-%D1%88%D0%B8%D0%BD%D1%8D%D1%87%D0%B8%D0%BB%D1%81%D1%8D%D0%BD-%D0%BD%D0%B0%D0%B9%D1%80%D1%83%D1%83%D0%BB%D0%B3%D0%B0> Олон нийтээр хэлэлцүүлж буй хуулийн төсөл.

² Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын 2.3, 4.3 дахь зохицуулалт.

- Үүрэг гүйцэтгэхэд зарцуулах хугацааг тогтооход бодитой хандах;³
- Бодит тоо баримт, мэдээлэлд тулгуурлах;⁴
- Аргачлалд заасан тооцоо хийх үе шатыг баримтлах.⁵

Зардал тооцоход шаардлагатай тоон мэдээллийг Оюуны өмчийн газраас гаргуулан авсан бөгөөд оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн төлөөлөлтэй ярилцлага хийсэн. Мөн төрийн албан хаагчийн зарцуулах цаг хугацааг тооцохдоо Оюуны өмчийн газрын шинжээчтэй ярилцлага хийж, ажиглалтын болон баримт бичиг судлах аргыг ашигласан болно.

НЭГ.ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДЛЫГ ТООЦОХ

Иргэнд үүсэх зардлыг тооцохдоо аргачлалын 3.1-д заасны дагуу:

- 1) Иргэний гүйцэтгэх үүргийг тогтоох;
- 2) Цаг хугацаа болон гарч болох зардлыг тооцох;
- 3) Тоон үзүүлэлтийг тооцох;
- 4) Нийт зардлын дүнг тооцож гаргах;
- 5) Хялбарчлах боломжийг шалгах үе шатаар хуульд заасан үүргээ гүйцэтгэхтэй холбогдон зарцуулах хугацаа, мөнгөн зардлыг⁶ тооцсон.

Патентын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд мэдүүлэг гаргагчид⁷ хамаарах тодорхой үүргийг шинээр хүлээлгэсэн байна.

Дэлгэрэнгүй мэдээллийг /Хүснэгт-1/-ээс харна уу.

Хуулийн төсөлд тухайн үүргийг яагаад нэмж тусгах болсон шалтгааныг судлахад зарим үүрэг нь мэдүүлэг гаргагчид шинээр хүлээлгэж байгаа бус, тус хуулийг хэрэгжүүлэх хүрээнд батлагдсан журмаар зохицуулж, практикт хэрэгжүүлж хэвшсэн үүрэг байна. Өөрөөр хэлбэл, тус үүргийг хэм хэмжээний акт буюу журмаар зохицуулж байсныг өөрчилж, хуулийн зохицуулалтын хүрээнд хамруулан зохицуулж

³ Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын 2.4.4, 4.4 дэх зохицуулалт.

⁴ Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын 4.4.3.1 дэх зохицуулалт.

⁵ Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын 2.1, 4.1 дэх зохицуулалт.

⁶ Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын 3.1.

⁷ “Гүйцэтгэх үүрэг” гэж тухайн хууль тогтоомжийн үйллэлд хамаарах этгээд хуульд заасны дагуу тоо баримт, тайлан, холбогдох бусад мэдээллийг бэлтгэн төрийн байгууллага буюу гуравдагч этгээдэд гаргаж өгөх, эсхүл хүргүүлэхийг хэлнэ. Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалын 2.3 дахь хэсэг болон 3.3 дахь хэсэг.

байгаагийн хувьд шинэ боловч тус үүргийг хэрэгжүүлэгчийн хувьд шинэ үүрэг биш юм.

Иймд нэгэнт практикт хэрэгжиж хэвшин тогтсон үүргийг шинээр зардал шаардсан чиг үүрэг хэмээн үзэж, түүний зардлыг тооцох нь ач холбогдолтой биш тул эдгээр чиг үүргийг зардал тооцох хүрээнд хамруулаагүй болно.

Хүснэгт -1

Хуулийн төслийн зохицуулалт		Үнэлгээ хийхээр сонгосон эсэх
1	15.3.Монгол Улсад байнга оршин суудаггүй Монгол Улсын иргэн, харьяалалгүй хүн, гадаадын иргэн, гадаад улсын хуулийн этгээд шинэ бүтээл, ашигтай загварын патентын мэдүүлгийг оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр төлөөлүүлэн гаргана.	Монгол Улсад байнга оршин суудаггүй Монгол Улсын иргэн, харьяалалгүй хүн, гадаадын иргэн, гадаад улсын хуулийн этгээд шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварын мэдүүлэг гаргах бол заавал оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр төлөөлүүлэхээр заасан нь тэдэнд шинээр хүлээлгэсэн үүрэг тул зардал тооцох шаардлагатай гэж үзэв.
2	32.3.Монгол Улсад байнга оршин суудаггүй Монгол Улсын иргэн, харьяалалгүй хүн, гадаадын иргэн, гадаад улсын хуулийн этгээд бүтээгдэхүүний загварын патентын мэдүүлгийг оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр төлөөлүүлэн гаргана.	
3	25.1.Шинэ бүтээлийн патентын мэдүүлгийн мөн чанарын шүүлтийг оюуны өмчийн байгууллага анхдагч огнооноос хойш, эсхүл олон улсын мэдүүлгийг Монгол Улсад хүлээн авсан өдрөөс хойш 24 сарын дотор мэдүүлэг гаргагчийн хүсэлтээр гүйцэтгэнэ. Энэ тохиолдолд үйлчилгээний хөлс төлнө.	Шинэ бүтээлийн патентын мэдүүлэгт мөн чанарын шүүлт хийлгэхэд мэдүүлэг гаргагч заавал хүсэлт гаргаж, үйлчилгээний хөлс төлсөн байхыг шаардаж байгаа тул зардал тооцох шаардлагатай гэж үзэв.
4	16.1.Шинэ бүтээл, ашигтай загварын патентын мэдүүлэг дараахь зүйлээс бүрдэнэ: 16.1.8.оюуны өмчийн байгууллагаас баталсан маягтын дагуу гаргасан зохион бүтээгчийн баталгаа;	Эдгээр нь хэдийгээр хуульд шинээр орсон зохицуулалт боловч шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварын мэдүүлэгт мэдүүлэг гаргагч нь тус бүтээлийг өөрөө зохион бүтээсэн болохоо баталсан зохион бүтээгчийн баталгаа хавсаргадаг нь тогтсон практик ⁸ тул үүнийг шинээр нэмэгдсэн үүрэг гэж үзэхгүй байна.
5	33.1.Бүтээгдэхүүний загварын мэдүүлэг дараахь зүйлээс бүрдэнэ:	

⁸ http://www.ipom.mn/index.php?option=com_content&task=view&id=46 Оюуны өмчийн газрын албан ёсны цахим хуудас, Шинэ бүтээлийн мэдүүлэг гаргахад бүрдүүлэх материал.

	33.1.4.Оюуны өмчийн байгууллагаас баталсан маягтын дагуу гаргасан зохион бүтээгчийн баталгаа;	Иймд зардал тооцох шаардлагагүй гэж үзэв.
6	Патентын тухай хуулийн төслийг дагаж гарах Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл “36.1.Шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварын патент, барааны тэмдэг, газар зүйн заалтын гэрчилгээ олгох, зохиогчийн эрхийн бүтээл болон зохиогчийн эрхэд хамаарах эрхийн бүтээлийг бүртгэж гэрчилгээ олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана: 36.1.1.шинэ бүтээлийн патент олгоход 25 000 төгрөг; 36.1.2.бүтээгдэхүүний загварын патент олгоход 25 000 төгрөг; 36.1.3.ашигтай загварын патент олгоход 25 000 төгрөг; 36.2.Шинэ бүтээлийн патентыг хүчинтэй байлгахад дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана: 36.2.1.эхний 5 жилд 40 000 төгрөг; 36.2.2.6-10 жилд 60 000 төгрөг; 36.2.3.11-15 жилд 80 000 төгрөг; 36.2.4.16-20 жилд 120 000 төгрөг; 36.3.Бүтээгдэхүүний загварын патентыг хүчинтэй байлгахад дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана: 36.3.1.эхний 5 жилд 40 000 төгрөг; 36.3.2.6-10 жилд 80 000 төгрөг; 36.3.3.11-15 жилд 120 000 төгрөг.	Уг хуулийн төслөөр улсын тэмдэгтийн хураамжийг нэмэгдүүлж байгаа тул нэмэгдүүлсэн хэмжээнд зардал тооцох шаардлагатай гэж үзэв. Харин Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 36.2.2-36.2.4, 36.3.2, 36.3.3 нь тухайн шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварыг цаашид хүчинтэй байлгах хүсэлтэй нөхцөлд л төлөгдөх учир зайлшгүй гарах зардал биш гэж үзэж зардал тооцох шаардлагагүй гэж үзлээ.

Дээрх дүн шинжилгээнд үндэслэн мэдүүлэг гаргагчид шинээр хүлээлгэсэн дараахь үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой үүсэх зардлыг тооцохоор сонгон авлаа.

- Шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварын мэдүүлэг гаргах бол оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр төлөөлүүлэх үүрэгтэй.
- Шинэ бүтээлийн патентын мэдүүлэгт мөн чанарын шүүлт хийлгэхэд мэдүүлэг гаргагч хүсэлт гаргаж, үйлчилгээний хөлс төлөх үүрэгтэй;
- Нэмэгдүүлсэн хэмжээгээр улсын тэмдэгтийн хураамж төлөх.

1.1. Монгол Улсад байнга оршин суудаггүй Монгол Улсын иргэн, харьяалалгүй хүн, гадаадын иргэн, гадаад улсын хуулийн этгээд шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварын мэдүүлэг гаргах бол оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр төлөөлүүлэх үүрэгтэй холбоотой үүсэх зардал:

Энэхүү үүргийн хүрээнд дараахь ажил хийгдэхээр байна:

1. Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй гэрээ байгуулах;
2. Итгэмжлэл үйлдэх;

Оюуны өмчийн газарт мэдүүлгийг монгол хэлээр гаргахаар заасан бөгөөд төлөөлөх эрхтэй этгээдээс мэдүүлэг хүлээн авах тул өнөөгийн практикт гадаад улсын иргэн, хуулийн этгээд ихэвчлэн хуулийн фирм, зөвлөх үйлчилгээний компани, эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчийн эрхтэй болон эрхгүй хувь хүнээс туслалцаа авч патентын мэдүүлэг гаргаж байна. Хуулийн төсөлд гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн, гадаад улсын хуулийн этгээд оюуны өмчийн газарт шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварын мэдүүлэг гаргах бол заавал оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр төлөөлүүлэхээр заасан тул дээрх мэдүүлэг гаргагчид өөрийгөө зөвхөн тусгай зөвшөөрөл бүхий оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр төлөөлүүлэх юм.

Патентын мэдүүлгийг 1 удаа гаргах тул **ДАВТАМЖИЙН ТООГ 1** гэж үзэж, тооцооллыг дараахь байдлаар гүйцэтгэлээ.

Хүснэгт –2

Агуулга	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа /мин	Давтамж	Ачаалал /мин/
Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй гэрээ байгуулах	Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч сонгох	30	1	30
	Үйлчилгээний нөхцөл, хөлс тохирох	30	1	30
	Гэрээ байгуулах	30	1	30
Итгэмжлэл	Итгэмжлэл үйлдэх	15	1	15

үйлдэх	Апостиль олгох	60	1	60
	Шуудангаар илгээх	15	1	15
Нийт-180 мин				

Энэхүү үүргийг гүйцэтгэхэд шаардагдах мөнгөн зардал нь оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн үйлчилгээний хөлс, апостиль үйлдүүлэхэд шаардагдах төлбөр болон шуудангийн зардал байна.⁹ Гэхдээ гадаадын иргэн, хуулийн этгээд нь Монгол Улсад мэдүүлэг гаргахдаа өөрийгөө итгэмжлэгдсэн төлөөлөгчийн эрхтэй, эсхүл эрхгүй этгээдээр төлөөлүүлдэг тул одоогийн практикт ч апостилиор итгэмжлэлээ баталгаажуулж, шуудангаар илгээдэг. Иймд үүнийг нэмэгдэх зардал гэж үзэх шаардлагагүй байна.

Харин оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр төлөөлүүлэхэд гарах ажлын хөлс нь шинээр нэмэгдсэн зайлшгүй гарах зардал тул үүнийг шинээр үүссэн зардал буюу ачаалал гэж үзнэ. Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн ажлын хөлсийг тогтоосон журам байхгүй тул төлөөлүүлэгчтэй харилцан тохиролцсоны үндсэн дээр ажлын хөлсөө гэрээгээр тохирч байна. Гадаадын мэдүүлэг гаргагчид үзүүлэх ажлын хөлс нь дунджаар 300 ам.доллар¹⁰ буюу 789,000 төгрөг¹¹ тул оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчид төлөх дундаж ажлын хөлсийг 789 000 гэж үзье.


Сүүлийн 5 жилд гадаадын иргэн, хуулийн этгээдээс ОӨБ-д хандаж гаргасан шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварын патентын мэдүүлэг гаргасан тооны дунджаар тохиолдлын тоог гаргалаа.

Зураг-1

⁹ Үнэлгээний хүрээнд оюун өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй хийсэн ярилцлагаас. 2019 он.

¹⁰ Үнэлгээний хүрээнд оюун өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй хийсэн ярилцлагаас. 2019 он.

¹¹ Монгол банкнаас зарласан 1 ам.долларын төгрөгтэй тэнцэх ханш 2019.03.23-ны байдлаар 2630 байв. /2630*300=789,000 төгрөг/



Дээрх тооноос үзвэл ОӨБ-д гадаадын мэдүүлэг гаргагчаас:

2014 онд 11 мэдүүлэг

2015 онд 21 мэдүүлэг

2016 онд 25 мэдүүлэг

2017 онд 28 мэдүүлэг

2018 онд 48 мэдүүлэг тус тус ирүүлсэн бөгөөд үүний дундаж нь $(11+21+25+28+48):5=26,6$ буюу ойролцоогоор жилд 27 мэдүүлэг байна.

Тиймээс жилд ирүүлдэг мэдүүлгийн тооны дунджаар **ТОХИОЛДЛЫН ТООГ 27** гэж тооцсон болно. Давтамж нь 1 тул **ТООН ҮЗҮҮЛЭЛТ 27** байна.

Энэхүү үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой мэдүүлэг гаргагчаас гарах нийт зардлыг тооцвол:

Нийт зардал=зардал*тоон үзүүлэлт гэсэн томъёогоор энэ үүргийг гүйцэтгэхэд гадаад улсын мэдүүлэг гаргагчид үүсэх нийт зардал:

$180 \text{ мин} * 27 = 4860 \text{ мин}$

$789 \text{ 000 төг} * 27 = 21 \text{ 303 000 төгрөг}$ байна.

1.2. Шинэ бүтээлийн патентын мэдүүлэгт мөн чанарын шүүлт хийлгэхэд мэдүүлэг гаргагч хүсэлт гаргаж, үйлчилгээний хөлс төлөх үүрэгтэй холбоотой үүсэх зардал:

Энэхүү үүргийн хүрээнд дараахь ажил хийгдэхээр байна:

1. Шинэ бүтээлийн мөн чанарын шүүлт хийлгэх хүсэлт ОӨБ-д гаргах;
2. Үйлчилгээний хөлс төлөх.

Мэдүүлэг гаргагч нь иргэн, хуулийн этгээд байхаас үл хамааран оюуны өмчийн газарт шинэ бүтээлийн патент авахын тулд мөн чанарын шүүлт хийлгэх тухай хүсэлтийг мэдүүлэг гаргагч гаргах үүргийг хуулийн төсөлд тусгасан. 2006 онд батлагдсан Патентын тухай хуульд мэдүүлэг гаргагчийг хүсэлт гаргахыг шаардахгүйгээр, мөн нэмэлт төлбөргүйгээр шинэ бүтээлийн бүх мэдүүлэгт мөн чанарын шүүлт хийдэг байсан тул энэ нь шинээр нэмэгдсэн үүрэг юм.

Мөн чанарын шүүлт хийлгэх тухай хүсэлтийг 1 удаа гаргах тул **ДАВТАМЖИЙН ТООГ 1** гэж үзэж, тооцооллыг дараахь байдлаар гүйцэтгэлээ.

Хүснэгт –3

Агуулга	Стандарт үйл ажиллагаа	Хугацаа /мин	Давтамж	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/
Мөн чанарын шүүлт хийлгэх тухай хүсэлт гаргах	Хүсэлт бичих	30	1	30
	Хүсэлтээ тогтоосон хугацааны дотор оюуны өмчийн газарт хүргүүлэх	30	1	30
Үйлчилгээний хураамж төлөх	Үйлчилгээний хураамж банкинд төлөх	30	1	30
Нийт-90 мин				

Тохиолдлын тоог гаргахын тулд 2014-2018 онд ОӨБ-д ирүүлсэн шинэ бүтээлийн мэдүүлгийн нийт тооны дунджийг тооцлоо.

Зураг- 2



Дээрх тооноос үзвэл ОӨБ-д гадаадын мэдүүлэг гаргагчаас:

2014 онд 254 мэдүүлэг

2015 онд 233 мэдүүлэг

2016 онд 221 мэдүүлэг

2017 онд 229 мэдүүлэг

2018 онд 159 мэдүүлэг тус тус ирүүлсэн бөгөөд үүний дундаж нь $(254+233+221+229+159):5=219,2$ буюу ойролцоогоор жилд 219 мэдүүлэг байна.

Шинэ бүтээлийн дотоодын мэдүүлгийн жилийн дундаж буюу **ТОХИОЛДЛЫН ТОО 219** бөгөөд давтамж 1 тул **ТООН ҮЗҮҮЛЭЛТ 219** байна.

Хуулийн төслийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт заасны дагуу энэхүү үүргийг гүйцэтгэхэд мэдүүлэг гаргагч мөн чанарын шүүлт хийлгэх үйлчилгээний хураамжийг ОӨБ-д төлөх үүрэгтэй боловч хуулийн төслийн 58 дугаар зүйлийн 58.2 дахь хэсэгт үйлчилгээний хураамжийн хэмжээг Засгийн газар тогтоохоор заасан тул үйлчилгээний хураамжийг төлөхөд шаардагдах мөнгөн зардлыг тооцох боломжгүй байна.

Иймд энэ үүргийг гүйцэтгэхэд мэдүүлэг гаргагчаас гарах нийт зардал нь:

90 мин*219=19710 мин байна.

1.3. Нэмэгдүүлсэн хэмжээгээр улсын тэмдэгтийн хураамж төлөх

Мэдүүлэг гаргагч нь 2010 оны Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 36 дугаар зүйлд заасан хэмжээгээр улсын тэмдэгтийн хураамж төлдөг байсан тул хураамж төлөхөд шаардагдах хугацааны хувьд өөрчлөгдөхгүй. Харин хэмжээг нэмэгдүүлж байгаа тул өмнөхтэй харьцуулахад нэмэгдсэн хэмжээнд нэмэлт /материаллаг/ зардал үүсэхээр байна.

Хүснэгт-4

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, 2010 он	Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн төсөл	Нэмэгдсэн зардлын хэмжээ /буюу зөрүү үнэ/
36.1.1.шинэ бүтээлийн патент олгоход 2500 төгрөг; 36.1.2.бүтээгдэхүүний загварын патент олгоход 2500 төгрөг; 36.1.3.ашигтай загварын гэрчилгээ олгоход 2500 төгрөг;	36.1.1.шинэ бүтээлийн патент олгоход 25 000 төгрөг; 36.1.2.бүтээгдэхүүний загварын патент олгоход 25 000 төгрөг; 36.1.3.ашигтай загварын патент олгоход 25 000 төгрөг;	Шинэ бүтээлийн патент олгоход 22 500 бүтээгдэхүүний загварын патент олгоход 22 500 төгрөг; ашигтай загварын патент олгоход 22 500 төгрөг;
36.2.Шинэ бүтээлийн патентыг хүчинтэй байлгахад дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана: 36.2.1.эхний 3 жилд 10 000 төгрөг; 36.2.2.4-6 жилд 20 000 төгрөг;	36.2.Шинэ бүтээлийн патентыг хүчинтэй байлгахад дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана: 36.2.1.эхний 5 жилд 40 000 төгрөг;	Шинэ бүтээлийн патентыг хүчинтэй байлгахад дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана: эхний 5 жилд 16 800 төгрөг;
36.3.Бүтээгдэхүүний загварын патентыг хүчинтэй байлгахад дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана: 36.3.1.эхний 3 жилд 10000 төгрөг;	36.3.Бүтээгдэхүүний загварын патентыг хүчинтэй байлгахад дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана: 36.3.1.эхний 5 жилд 40 000 төгрөг;	36.3.Бүтээгдэхүүний загварын патентыг хүчинтэй байлгахад дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана: эхний 5 жилд 16 800 төгрөг;

36.3.2.4-6 жилд 20 000 төгрөг;		
--------------------------------	--	--

Оюуны өмчийн газраас жилд олгодог патент, гэрчилгээний тоог тооцохдоо 2013-2017 онд олгосон тооны дунджаар тооцсон болно.

Хүснэгт-5

	Шинэ бүтээлд олгосон тоо	Ашигтай загварт олгосон гэрчилгээний тоо	Бүтээгдэхүүний загварт олгосон патентын тоо
2013 он	212	121	285
2014 он	216	125	275
2015 он	223	150	228
2016 он	118	127	238
2017 он	104	164	221
Дундаж	174,6	137,4	249,4

Шинэ бүтээлийн патентын хувьд **ТОХИОЛДЛЫН ТОО 175**, ашигтай загварын хувьд **ТОХИОЛДЛЫН ТОО 137**, бүтээгдэхүүний загварын хувьд **ТОХИОЛДЛЫН ТОО 249** байна. Патент олгоход төлөх¹² улсын тэмдэгтийн хураамжийг /цаашид “УТХ” гэх/ хуулийн төсөлд заасан хэмжээгээр төлөхөд мэдүүлэг гаргагчаас нэмэгдэж гарах зардлыг дараахь байдлаар тооцлоо.

Хүснэгт-6

	Нэмэгдсэн хэмжээ /төг/	Тохиолдлын тоо	Ачаалал /төг/
Шинэ бүтээлийн патент авахад төлөх УТХ	22 500	175	3 937 500
Ашигтай загварын патент авахад төлөх УТХ	22 500	137	3 082 500
Бүтээгдэхүүний загварын патент авахад төлөх УТХ	22 500	249	5 602 500
Нийт ачаалал /төг/			12 622 500

¹² Хуульд заасан шаардлага хангасан бүтээлд патент, гэрчилгээ олгодог тул патент, гэрчилгээ олгосон тоо нь мэдүүлгийн тооноос бага байна.

Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварыг эхний 5 жил¹³ хүчинтэй байлгахад төлөх УТХ-ыг нэмэгдүүлсэн хэмжээгээр төлөхөд мэдүүлэг гаргагчид үүсэх ачааллыг дараахь байдлаар тооцлоо.

Хүснэгт-7

	Нэмэгдсэн хэмжээ /төг/	Тохиолдлын тоо	Ачаалал /төг/
Шинэ бүтээлийн патент авахад төлөх УТХ	16 800	175	2 940 000
Бүтээгдэхүүний загварын патент авахад төлөх УТХ	16 800	249	4 183 200
Нийт ачаалал /төг/			7 123 200

УТХ-ийг хуулийн төсөлд заасан хэмжээгээр төлөхөд иргэний зарцуулах хугацаанд өөрчлөлт орохгүй, харин материаллаг зардал нэмэгдэхээр байна.

Улсын тэмдэгтийн хураамжийг хуулийн төсөлд заасан хэмжээгээр төлөхөд мэдүүлэг гаргагчаас гарах зардал нь дараахь хэмжээтэй байна:

12 622 500+7 123 200=19 745 700 төгрөг байна.

ХОЁР.ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ҮҮСЭХ ЗАРДАЛ

Патентын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар төрийн байгууллага буюу улсын төсөвт үүсэх ачааллыг тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлсны үндсэн дээр түүнд шаардагдах зардлыг тооцох замаар дараахь үе шатаар гүйцэтгэлээ:

1. Хуулийн төсөлд тусгагдсан төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээ нэг бүрийг тодорхойлох;
2. Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хугацааг тодорхойлсны үндсэн дээр шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээг тогтоох;
3. Хүний нөөцтэй холбоотой гарах зардлыг урьдчилан тооцох;
4. Бусад зардал буюу материаллаг зардлыг нэгтгэн тооцох;
5. Хувилбарыг нягтлах.

¹³ Мэдүүлэг гаргагч шаардлагатай гэж үзсэн тохиолдолд 5 дахь жилээс хойших УТХ-ийг төлдөг тул үүнээс хойших УТХ төлөх нь заавал гүйцэтгэх үүрэг биш гэж үзэв.

Хуулийн төслөөр төрийн байгууллагад шинээр хүлээлгэсэн үүрэг буюу ажил үйлчилгээг нэг бүрчлэн түүвэрлэж, хийж гүйцэтгэх ажлыг дараахь байдлаар тодорхойллоо:

Хүснэгт -8

	Хуулийн төслөөр төрийн байгууллагад шинээр хүлээлгэсэн үүрэг	Үнэлгээ хийхээр сонгосон эсэх
1	22.9.Оюуны өмчийн байгууллага нь энэ хуулийн 17, 18, 20 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан эсэхийг тогтоох зорилгоор ашигтай загварын мэдүүлгийн бүрдлийн шүүлтийг анхдагч огнооноос хойш хоёр сар, шинэ бүтээлийн мэдүүлгийн бүрдлийн шүүлтийг анхдагч огнооноос, эсхүл олон улсын мэдүүлгийг Монгол Улсад хүлээн авсан өдрөөс хойш дөрвөн сарын дотор хийнэ.	Мэдүүлгийн бүрдлийн шүүлт нь мэдүүлгийн тодорхойлолт, томъёолол, зураг, бүдүүвч нь хууль, журамд заасан шаардлага хангахуйц түвшинд хийгдсэн эсэхийг шалгах ажиллагаа бөгөөд үүнийг хийхгүйгээр хайлт, мөн чанарын шүүлтийн ажиллагаа хийгдэх боломжгүй юм. ¹⁴ Энэхүү ажиллагаа нь заавал хийгддэг ажиллагаа боловч 2006 оны Патентийн тухай хуульд тодорхой тусгагдаагүй байсныг хуулийн төсөлд тусгайлан заасан тул энэ үүрэг нь ОӨБ-ын хувьд шинээр бий болсон үүрэг биш юм. Иймд тус чиг үүргийг гүйцэтгэхтэй холбоотой зардал тооцох шаардлагагүй гэж үзлээ.
2	24.1.Оюуны өмчийн байгууллага нь энэ хуулийн 17, 18, 20 дугаар зүйлд заасан шаардлагыг бүрэн хангасан патентын мэдүүлэгт шинэ бүтээл, ашигтай загварын техникийн өмнөх түвшинг тогтоох зорилгоор хайлт хийж, тайлан гаргана.	Хайлтын ажиллагаа нь шинэ бүтээл, ашигтай загварын техникийн өмнөх түвшинг тогтоож, харьцуулах ажиллагаа бөгөөд үүнийг хийхгүйгээр мөн чанарын шүүлт хий, шинэ бүтээл, ашигтай загвар нь “шинэ” эсэхийг тогтоох боломжгүй тул хуульд тусгайлан заагаагүй ч заавал хийгддэг ажиллагаа юм. ¹⁵ Энэхүү ажиллагаа нь 2006 оны Патентийн тухай хуульд тусгагдаагүй боловч ОӨБ хийдэг байсан тул шинээр бий болсон үүрэг биш юм. Харин мэдүүлэг гаргагчид хүргүүлэх зорилгоор хайлтын тайлан гаргах нь шинээр бий болсон үүрэг тул зөвхөн “тайлан гаргах” үүргийг гүйцэтгэхтэй холбоотой зардал тооцох шаардлагатай гэж үзлээ.
3	24.6.Шинэ бүтээлийн хайлтын тайланг мэдүүлэг гаргагчид хүргүүлсэн	Харин шинэ бүтээлийн хайлтын тайланг нийтлэх үүрэг нь шинээр нэмэгдсэн тул

¹⁴ Үнэлгээний хүрээнд оюуны өмчийн газрын шинжээчтэй хийсэн ярилцлага, 2019 он.

¹⁵ Үнэлгээний хүрээнд оюуны өмчийн газрын шинжээчтэй хийсэн ярилцлага, 2019 он.

өдрөөс хойш 30 хоногийн дотор ном зүй, тодорхойлолт, томъёолол, товч тайлбар, зураг, бүдүүвчийг албан ёсны тогтмол хэвлэлд нийтэлнэ.	үүнтэй холбоотой гарах зардал тооцох шаардлагатай гэж үзлээ.
--	---

Хуулийн төсөлд тусгагдсаны дагуу оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага /цаашид “ОӨБ” гэх/ нь дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр зохицуулсныг сонгон гарах зардлыг тооцлоо:

Үүнд:

- Шинэ бүтээл, ашигтай загварт хайлтын тайлан гаргах;
- Шинэ бүтээлийн хайлтын тайланг мэдүүлэг гаргагчид хүргүүлж, ном зүй, тодорхойлолт, томъёолол, товч тайлбар, зураг, бүдүүвчийг албан ёсны тогтмол хэвлэлд нийтлэх.

Харин аргачлалын 4.4.6-д заасны дагуу төрийн байгууллагаас хэрэгжүүлэх бодлогын шинжтэй ажил буюу журам батлах, шинэчлэн боловсруулах зэрэг ажиллагаанд зардал тооцох шаардлагагүй гэж үзэв. Түүнчлэн хуулийн төсөлд мэдүүлэг гаргагч зохих үйлчилгээний хөлс төлж, хүсэлт гаргасан тохиолдолд ОӨБ хугацаа сунгах, мэдүүлэгт өөрчлөлт оруулах¹⁶ зэрэг ажиллагааг хийхээр тусгасан нь ОӨБ-ын зайлшгүй хийх ажиллагаа биш тул зардал тооцох шаардлагагүй гэж үзэв.

2.1. Шинэ бүтээл, ашигтай загварын хайлтын тайлан гаргах:

Тус үүргийг гүйцэтгэхэд дараахь ажлыг хийх шаардлагатай байна:

1. Хайлтын тайлан боловсруулах;
2. Техникийн өмнөх түвшинтэй харьцуулсан дүгнэлт бичих.

Шинэ бүтээл, ашигтай загварын хайлтын тайлан гаргахад ОӨБ-д үүсэх хүний нөөцийн хэрэгцээг тооцоолохын тулд юуны өмнө үйл ажиллагаа бүрийг хэрэгжүүлэх арга хэмжээнд задлан, уг арга хэмжээг хэрэгжүүлэхэд хийгдэх алхам тус бүрийг тодорхойлж, түүнд зарцуулах хугацааг тооцов.

Хайлтыг анхдагч огноо тогтоолгосон шинэ бүтээл, ашигтай загварын бүх мэдүүлэгт хийх тул тохиолдлын тоог гаргахын тулд оюуны өмчийн газарт 2014-2018 онд гаргасан шинэ бүтээл, ашигтай загварын мэдүүлгийн тооны дунджийг тооцлоо.

¹⁶ Хуулийн төслийн 16.5, 16.8, 21.3, 21.7, 22.5, 22.6, 22.8, 22.10, 22.13, 22.14, 23.2, 24.4, 35.4, 41.3, 51.2 дахь хэсгүүд



Оюуны өмчийн байгууллагын 2014-2018 онд хүлээн авсан шинэ бүтээл, ашигтай загварын нийт мэдүүлгийн дундаж нь $(448+381+435+487+382)/5=426.6$

Оюуны өмчийн байгууллага жилд дунджаар 426,6 шинэ бүтээл, ашигтай загварын мэдүүлэг хүлээн авдаг тул **ТОХИОЛДЛЫН ТОО 427** гэж тооцлоо.

Оюуны өмчийн байгууллага нь одоо байгаа хүний нөөцийн хүрээнд хайлтын ажиллагааг шинэ бүтээл, ашигтай загварын мэдүүлэг бүрт хийдэг тул хайлтын ажиллагаа хийхэд шаардагдах хүний нөөцийн зардлыг тооцоогүй. Харин хайлтын тайлан гаргаж, мэдүүлэг гаргагчид хүргүүлэх ажиллагаа нэмэгдсэн тул тус хийсэн хайлтын ажиллагааны эцэст тайлан боловсруулах үйл ажиллагаанд зарцуулах хугацааг тооцох шаардлагатай гэж үзлээ. Ингэхдээ төрийн байгууллагад хийгддэг адил төстэй үйлчилгээг судалж, холбогдох мэргэжилтнүүдийн ажилбарт шаардагдах хугацаан дээр үндэслэн тэдгээрийн гүйцэтгэх хугацааг тодорхойлон тооцлоо.

Хүснэгт-9

Байгууллагын үүрэг	Агуулга	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа /мин/	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/
Шинэ бүтээл,	Техникийн	Техникийн	10	427	4270

ашигтай загварын хайлтын тайлан гаргах	өмнөх түвшинг судалсан тухай тайлан боловсруулах	өмнөх түвшинг тогтоох боломжтой эсэхийг дүгнэх			
		Техникийн өмнөх түвшинд хамаарах бүтээлүүдийг жагсаах	20	427	8540
	Техникийн өмнөх түвшинг харьцуулах	Шинэ бүтээл нь техникийн өмнөх түвшингээс ялгаатай эсэхийг тогтоох	30	427	12810
		Ялгарах шинж болон ижил байдалд дүгнэлт хийх	30	427	12810
Нийт 90 мин				38430 мин	

Шаардагдах ажлын цагийг Хөдөлмөрийн тухай хуульд тусгагдсан ажиллах цагийн горимтой харьцуулан авч үзнэ.

Ингэхдээ нэг төрийн албан хаагч нэг жилд ажиллах өдөр, цаг, минут гэсэн хэмжигдэхүүнд тулгуурлана.

- 1 жил = ажлын 200¹⁷ өдөр
- 1 өдөр = ажлын 8 цаг /хөдөлмөрийн хуулийн дагуу/
- 1 цаг = ажлын 60 минут
- Жилд 200 ажлын өдөр буюу /200 х 8/ 1600 ажлын цаг буюу /1600 х 60/ 96000 минут ажиллана.

Ийнхүү үйл ажиллагаа тус бүрт зарцуулах хугацааг нэгтгэн, шаардагдах нийт ажлын цагийг гаргаж уг ажилд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг дараахь байдлаар гаргалаа.

Хүснэгт-10

Нэгж	Хүний нөөцийн хэрэгцээ	Жилд шаардагдах ажлын цаг/мин	Нэмэгдэж буй ачаалал /орон тоо/
ОӨБ	38,430	96000	0,4

¹⁷ Хуанлийн 365 хоногоос хөдөлмөрийн хуулинд заасан нийтээр амрах байрын өдөр, ээлжийн амралт, хагас бүтэн сайн өдөр зэргийг хасаж бодитой ажиллах өдрийг тооцно.

--	--	--	--

38,430 мин/60 мин=640 цаг/ ажлын 8 цаг= 80 өдөр

Шинэ бүтээл, ашигтай загварт хайлтын тайлан гаргах чиг үүргийг гүйцэтгэхэд Оюуны өмчийн газарт **80** өдрийн ачаалал үүсэх бөгөөд тухайн ажлыг хийж гүйцэтгэхэд **0,4 хүн** шаардлагатай гэсэн тооцоолол гарч байна.

Өөрөөр хэлбэл, энэхүү шинэ бүтээл, ашигтай загварын хайлтын тайлан гаргах ажиллагааг хийхэд орон тоо нэмэх шаардлагагүй, одоо байгаа хүний нөөцийн хүрээнд уг чиг үүргийг гүйцэтгүүлэх боломжтой байна.

2.2. Хайлтын тайлан гарсны дараа шинэ бүтээлийн ном зүй, тодорхойлолт, томьёолол, товч тайлбар, зураг, бүдүүвчийг албан ёсны тогтмол хэвлэлд нийтлэх:

Энэхүү үүргийг гүйцэтгэхэд ОӨГ дараахь ажлуудыг хийх шаардлагатай байна:

1. Шинэ бүтээлийн ном зүй, тодорхойлолт, томьёолол, товч тайлбар, зураг, бүдүүвчийг албан ёсны тогтмол хэвлэлд нийтлэхэд бэлтгэх;
2. Албан ёсны тогтмол хэвлэлд нийтлэх;

Дээрх үүргийг гүйцэтгэхэд ОӨГ-т үүсэх хүний нөөцийн зардлыг дараахь байдлаар гаргалаа.

2006 оны Патентийн тухай хуульд шинэ бүтээлийн мэдүүлэгт мөн чанарын шүүлт хийсний дараа л албан ёсны тогтмол хэвлэлд цахимаар нийтэлдэг байсан бол хуулийн төсөлд заасны дагуу олон улсын нийтлэг жишигт нийцүүлэн дараахь тохиолдолд тухайн бүтээлийн талаар албан ёсны хэвлэлд нийтлэхээр байна:

- 1.Хайлтын тайлан гарсны дараа /шинээр нэмэгдсэн/;
- 2.Мөн чанарын шүүлтийн тайлан гарсны дараа /өмнө байсан/¹⁸.

Доор дурдсан байдлаар 2014-2018 онд ОӨБ-д ирүүлсэн шинэ бүтээлийн мэдүүлгийн дундаж тоогоор тохиолдлын тоог тооцъё:

Хүснэгт 11

	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он
ОӨБ-д ирүүлсэн шинэ бүтээлийн нийт мэдүүлгийн тоо	254	233	221	229	159

¹⁸ Патентийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.11 дэх хэсэг.

ОӨБ-д ирүүлсэн шинэ бүтээлийн мэдүүлгийн тооны жилийн дундаж нь $(254+233+221+229+159):5=219,2$ тул **ТОХИОЛДЛЫН ТОО 219** байна.

Хүснэгт-12

Байгууллагын үүрэг	Агуулга	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа /мин/	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/
Хайлтын тайлан гарсны дараа шинэ бүтээлийн ном зүй, тодорхойлолт, томъёолол, товч тайлбар, зураг, бүдүүвчийг албан ёсны тогтмол хэвлэлд нийтлэх	Шинэ бүтээлийн ном зүй, тодорхойлолт, томъёолол, товч тайлбар, зураг, бүдүүвчийг албан ёсны тогтмол хэвлэлд нийтлэхэд бэлтгэх;	Шинэ бүтээлийн ном зүй, тодорхойлолт, томъёолол, товч тайлбар, зураг, бүдүүвчийг хянаж, албан ёсны тогтмол хэвлэлд нийтлэхэд бэлтгэх;	20	219	4380
	Албан ёсны тогтмол хэвлэлд нийтлэх	Албан ёсны тогтмол хэвлэлд цахимаар нийтлэх	10	219	2190
Нийт 30 мин				6570 мин	

Ийнхүү үйл ажиллагаа тус бүрт зарцуулах хугацааг нэгтгэн, шаардагдах нийт ажлын цагийг гаргаж уг ажилд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг дараахь байдлаар гаргалаа.

Хүснэгт 13

Нэгж	Хүний нөөцийн хэрэгцээ/ мин	Жилд шаардагдах ажлын цаг/мин	Нэмэгдэж буй ачаалал /орон тоо/
ОӨГ	6570	96000	0.068

$$6570 \text{ мин} / 60 \text{ мин} = 109,5 \text{ цаг} / \text{ажлын 8 цаг} = 13,6 \text{ өдөр}$$

Дээрх хүснэгтээс харахад уг чиг үүргийг гүйцэтгэхэд **1 төрийн албан хаагч жилд 13,6 өдөр** зарцуулахаар байгаа тул шинээр орон тоо бий болгох

шаардлагагүй, одоо байгаа хүний нөөцийн хүрээнд уг ажиллагааг гүйцэтгүүлэх боломжтой байна.

ДҮГНЭЛТ

Патентын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг батлан хэрэгжүүлэхэд гарах зардлын тооцоог хийж, уг хуулийн төслийг хэрэгжүүлэхэд иргэнд болон төрийн байгууллагад үүсэх зардлыг тооцооллоо.

1/ Иргэнд үүсэх зардал

Хуулийн төслөөр иргэнд¹⁹ хүлээлгэсэн үүргээс зайлшгүй хэрэгжүүлэх дараахь 3 үүргийг сонгон авч, түүнийг гүйцэтгэхэд зарцуулах хугацаа болон гаргах материаллаг зардлыг тооцооллоо:

Хүснэгт 14

№	Мэдүүлэг гаргагчид хүлээлгэсэн үүрэг	Зарцуулах хугацаа /мин/	Материаллаг зардал /төгрөг/
1	Монгол Улсад байнга оршин суудаггүй Монгол Улсын иргэн, харьяалалгүй хүн, гадаадын иргэн, гадаад улсын хуулийн этгээд шинэ бүтээл, ашигтай загвар, бүтээгдэхүүний загварын мэдүүлэг гаргах бол оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр төлөөлүүлэх	4860	21,303,000
2	Шинэ бүтээлийн патентын мэдүүлэгт мөн чанарын шүүлт хийлгэхэд мэдүүлэг гаргагч хүсэлт гаргаж, үйлчилгээний хөлс төлөх.	19710	--
3	Нэмэгдүүлсэн хэмжээгээр лсын тэмдэгтийн хураамж төлөх	--	19,745,700
Нийт		24,570 мин	41,048,700 төгрөг

¹⁹ Хуулийн төсөлд “мэдүүлэг гаргагч”-ийг 1/иргэн, хуулийн этгээд гэж ялгахгүйгээр үүрэг хүлээлгэсэн, 2/ оюуны бүтээлийг туурвигч буюу зохион бүтээгч нь хувь хүн байх, 3/ гадаад улсад үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдийн ажилтны хөлс нь тухайн улсын дундаж цалин хөлс, хуулийн этгээдийн хэмжээ, үйл ажиллагааны салбараасаа шалтгаалан хэт ялгаатай, дунджаар тооцох боломжгүй учир хуулийн этгээдэд зардал тооцохгүйгээр иргэний зардалд нийлүүлэн тооцооллоо.

Хуулийн төсөлд шинээр хүлээлгэсэн дээрх үүргүүдийг гүйцэтгэхэд мэдүүлэг гаргагчдаас нийт 24,570 минут буюу 409,5 цаг зарцуулж, 41,048,700 төгрөгийн зардал гарахаар байна.

Түүнчлэн дээрх үүргүүд нь хоорондоо давхцаагүй, заавал хийгдэх шаардлагатай бөгөөд үүсэх зардал, ачаалал нь зохистой түвшинд байгаа тул зардлыг бууруулах талаар арга хэмжээ авах тухайд өгөх саналгүй байна.

2/Төрийн байгууллагад үүсэх зардал

Патентын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн дагуу төрийн байгууллагад шинээр бий болгосон доорх 2 үүргийг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн зардал болон материаллаг зардлыг дараахь байдлаар тооцооллоо:

Хүснэгт 15

№	Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг	Шинээр шаардагдах орон тоо /хүний нөөцийн зардал/	Материаллаг зардал /төгрөг/
1	Шинэ бүтээл, ашигтай загварт хайлтын тайлан гаргах;	0,4	--
2	Шинэ бүтээлийн хайлтын тайланг мэдүүлэг гаргагчид хүргүүлж, ном зүй, тодорхойлолт, томъёолол, товч тайлбар, зураг, бүдүүвчийг албан ёсны тогтмол хэвлэлд нийтлэх.	0,068	--
Нийт		0,468 орон тоо	--

Энэхүү хуулийн төсөл батлагдсанаар төрийн байгууллагад шинээр үүсэх хүний нөөцийн хэрэгцээ нь нийт 45,000 минут буюу 0,468 орон тоо тул дээрх үүргүүдийг гүйцэтгэхэд зориулан шинээр орон тоо нэмэх шаардлагагүй бөгөөд материаллаг зардал гарахгүй.

Түүнчлэн шинээр бий болсон дээрх үүргүүд нь бусад үүргүүдтэй давхцаагүй, гүйцэтгэх шаардлагатай үүргүүд тул зардлыг бууруулах арга хэмжээ авах талаар өгөх саналгүй байна.

-----oOo-----

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

- Патентийн тухай хууль, 2006 он;
- Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, 2010 он;
- Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт, “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”
- Патентын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл. 2018 он;
- Патентын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, танилцуулга. 2018 он;
- Оюуны өмчийн газрын статистик мэдээлэл. 2019 он;
- Оюуны өмчийн газрын албан ёсны цахим хуудас. www.ipom.mn
- Монголбанкны албан ёсны цахим хуудас. www.mongolbank.mn